

# ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГАНБААТАРЫН БАТБААТАРЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Сонгуулийн уриа: Хийхээрээ биш, хийснээрээ бахархая.**

Энэхүү мөрийн хөтөлбөр нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрэв ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот бодит ажлууд мөн нэр дэвшиж буй баг дээр шийдвэрлэх хийж хэрэгжүүлэх, зорилго зорилтуудыг 2 хэсэгт багтааж томъёолж өгсөн болно.

**Зорилт 1. Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд:**

- 1.1 Орхон аймаг Эрдэнэт хотын ард иргэд байгалийн баялагтаа эзэн байх үр шимийг нь хүртэх талаар Эрдэнэт хотоос УИХ-д сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.
- 1.2 Залуучуудад зориулсан “Ажилтай оролготой монгол залуучууд” дэд хөтөлбөр боловсруулж залуу гэр бүл, залуу боловсон хүчин, зорилтод бүлгийн залуучуудад чиглэсэн ажлын байр олноор бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3 Ажлын байр нэмэгдүүлэх гол эх үүсвэр нь жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ түүнийг дэмжих сан болон бусад дэмжлэгийн сангуудын үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй байхад анхаарч ажиллана.
- 1.4 Эрдэнэт хотын захиргаа, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд байгаль орчны бохирдол, хүн, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй асуудлууд, гол ус, хөрсний бохирдол, цагаан тоосыг арилгах тал дээр онцгой анхаарч ажиллана.
- 1.5 Хотын хүн ам өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн хангалт хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр үе шаттай бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6 Иргэдэд эрүүл мэндийн анхан шатны эмнэлэгийн тусламж үзүүлдэг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд анхаарал хандуулж бүсийн оношлогооны төв зэрэг томоохон хэвтэн эмчлүүлэх эмнэлгүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, зайлшгүй шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлэгийн ажилтнуудыг давтан сургах, иргэд эрүүл мэндийн үйлчилгээг саадгүй түргэн шуухай авч байх тал дээр анхаарч ажиллана.

61171436  
90073 9042806  
Г. Ганбаатар



- 1.7 Гэр хороололд амьдарч буй иргэдэд агаар хөрсний бохирдлыг арилгах, тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, хогны менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.
- 1.8 Орон сууцны хорооллуудын авто зам, зогсоол, явган замыг өргөтгөж, зохион байгуулалтыг сайжруулж, гэр хорооллын асфальтан болон сайжруулсан авто зам болон явган замыг үе шаттайгаар нэмэгдүүлж эрүүл цэвэр орчин бий болгох зорилгоор ногоон байгууламжуудийг олноор байгуулж хотын гудамж, зам талбайнуудыг дугуйн замтай болгох ажлыг эхлүүлж мэргэжлийн байгууллагаар зураг төсөл, холбогдох судалгааг хийлгэж, эхлүүлнэ.
- 1.9 Нийтийн тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулах тал дээр анхаарч хот доторх тээвэрлэлтийг нэмэгдүүлж, хот хоорондын зорчигч тээврийн стандартын авто вокзалтай болох асуудлыг шийдвэрлэх чиглэлээр нь холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.10 Залуучуудын, нийгмийн салбарын олон талт төрийн бус байгууллагуудтай болон нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд үйл ажиллагаа явуулж буй клуб, секц дугуйлан спорт холбоодын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.11 Хүүхэд багачууд чөлөөт цагаа өнгөрөөх, чийрэгжүүлэх тоглоомын талбайг хотын төвийн болон гэр хорооллын багуудаар үргэлжлүүлэн хийх тал дээр анхаарч ажиллана.
- 1.12 Хотын ДЦС-ын өргөтгөл хийгдэж, цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нэмэгдэж байгаатай холбоотой ажлууд дээр дэмжин хамтран ажиллана.
- 1.13 Ахмад настан болон зорилтод бүлэгт чиглэсэн дэмжсэн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ. Өндөр настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү хандсан нийгмийн дэмжлэгийг чирэгдэлгүй хүртэх тал дээр анхаарч ажиллана.
- 1.14 Орхон аймаг Эрдэнэт хот болж байгаатай уялдуулан хотын соёлыг нийтэд түгээх “Эрдэнэт бол залуусын хот” уриалгыг нийгэмд түгээж, залуучуудад зориулсан олон талт сайн санал, санаачлагыг дэмжиж хамтран ажиллана.


Энэхүү мөрийн хөтөлбөр нь УИХ-аас баталсан Монгол улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, болон Алсын хараа 2050 үзэл баримтлалын бодлоготой нягт уялдан хэрэгжих юм.






## Зорилт 2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

- 2.1 Багийн хэмжээнд орон сууцнуудын хуучирч муудсан инженерийн шугам сүлжээг үе шаттай засварлах, солих, орон сууцнуудын байрны дээвэр, заадсын засвар, халаалт дулаан алдагдлыг чанартай түргэн шуурхай, баталгаатай засаж сайжруулаж байх тал дээр анхаарч иргэд оршин суугчид өөрсдөө хяналт тавьдаг хамтарч ажилладаг зохицуулалтыг хангана.
- 2.2 Орон сууцны байрны гаднах хүүхдийн тоглоомын талбайн ашиглалтыг сайжруулах засаж янзлах, үе шаттай нэмэгдүүлэхэд эргэн тойрныг ногоон байгууламжтай болгох тал дээр анхаарч ажиллана.
- 2.3 Гэр хорооллын гудамж хоорондын авто замын нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлж, өргөтгөх, гэрэлтүүлгүүдийг нэмэх, орон сууцны гаднах авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, явган замыг сайжруулах, үер уснаас хамгаалах суваг шуудууны ажлуудыг хийх тал дээр анхаарал хандуулж шийдвэрлэнэ.
- 2.4 Багийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг багийн засаг даргын ажлын алба, цагдаагийн хэсэг, өрхийн эмнэлэг тэдгээрийн ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэдэг зохицуулалтыг бий болгож шинэ багийн байртай болох ажлыг холбогдох байгууллагуудад уламжилж ажил болгох тал дээр онцгой анхаарч ажиллана.
- 2.5 Багийн хэмжээнд харьяалал бүхий ажил хөдөлмөр идэвхитэй хайж байгаа залуучууд, иргэдэд туслах зорилгоор хөдөлмөрийн бирж ажиллуулах бодлого зохицуулалт хийх, зорилтод бүлгийн ахмад настан эцэг эхчүүд гэр бүлд зориулсан хөгжлийн төв байгуулах зэрэг аливаа санаачлагыг дэмжиж ажиллана.
- 2.6 Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж орчин нөхцөлийг сайжруулах тал дээр бодлогоор дэмжинэ.
- 2.7 Багийн нутаг дэвсгэрт буй гудамж талбайг тохижуулах, хуучин ногоон байгууламжийг арчилж тордох, шинээр бий болгох авто болон явган замыг үе шаттай нэмэгдүүлж, багийн иргэд өөрсдөө оролцож тарьж ургуулах, бүтээн байгуулах боломжийг нээж өгнө.



- 2.8 Багийн нутаг дэвсгэр дэх сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр байнга анхаарч ажиллана.
- 2.9 Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай холбогдуулан багийн хэмжээнд хотын соёлыг түгээх, олон талт ажлуудыг иргэдийн шууд оролцоотойгоор өргөн хүрээнд зохион байгуулна.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан:  Г.БАТБААТАР

